



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/398

Эрдэнэт

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2017 оны 8 дугаар сард ОХУ-ын Артек зусланд зохион байгуулагдах орос хэлний олон улсын тэмцээнд оролцохоор шалгарсан 14 дүгээр сургуулийн багш Очирхүү овогтой Энхжаргалд 2000000 /Хоёр сая/ төгрөгийн дэмжлэгийг үзүүлсүгэй.

2. Шаардагдах зардал 2000000 /Хоёр сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Боловсрол, эрүүл мэнд, спорт, урлагийн салбарын ажиллагсдын мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.



ЗАСАГ ДАРГА

Д. БАТЛУТ